



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймаг дахь шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2022/141/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533552 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Аудитор: Н.Хулан

Утас: 70533552 Цахим хаяг: khulann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу
Нэг. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймаг дахь шүүхийн Тамгын газар нь Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, мэргэшсэн, тогтвортой, шударга, хариуцлага хүлээдэг байх иргэдэд



гэх, шударга ёсны үйлчилгээг сайжруулж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх пон иргэний эрх зүйн ухамсар соёлыг дээшлүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл иллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Өмнөговь аймаг дахь шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- (Шүүн таслах үйл ажиллагааг хэвийн явуулах)

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Санхүүгийн байдлын тайлан		
	Үзүүлэлт	2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>5.5</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>1,103.0</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>1,108.5</u>
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1,108.5</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,058.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,043.8
	Үйл ажиллагааны үр дүн	<u>15.1</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>15.1</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,093.5
	Тайлант оны үр дүн	15.1
	Эцсийн үлдэгдэл	1,108.6
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>975.0</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	938.4
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>36.6</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>-36.6</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	925.2
	Урсгал зардал	925.2
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	925.2
	Улсын төсвөөс санхүүжих	925.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	

Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл



№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ									

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 21.8 сая төгрөгийн 1 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17.2 сая төгрөгийн худалдан авалтын 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.4.4 “*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*”, 6.4.5 “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “*үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1 “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” заалтыг тус тус хэрэгжүүлээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

Тав. Аудитын үр дүн

5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн	Үүнээс			
			Залруулга	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж



		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	39.2	0	0	1	0.2	1	39		
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ										

5.2 Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 39.2 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 акт, 39 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга байхгүй байна.

Акт:

Тайлант онд сахилгын шийтгэлтэй ажилтанд 0.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Албан шаардлага:

- Шилэн дансны мэдээллийг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 21.8 сая төгрөгийн 1 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17.2 сая төгрөгийн худалдан авалтын 2 мэдээллийг байршуулаагүй,
- Шатахууны зарцуулалтыг тулган баталгаажуулахад жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтлөөгүй, норм тооцоолох боломжгүй байна.

Зургаа. Аудитын санал дүгнэлт /баталгаажсан хувийг оруулах/



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.МӨНХТҮВШИН ТАНАА

2022.02.22 № 87
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Өмнөговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-02-22 №87\с

01330182